



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 06 сарын 04 өдөр

Дугаар А/326

Есөнбулаг сум

Орон нутгийн хамгаалалтын
хээрийн дадлага, сургалт зохион байгуулах
ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 зүйлийн 66.1 дэхь хэсэг, Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2, 11.3.2, 11.4.2, 11.6, 11.7, 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2026 оны 05 дугаар сарын 08-ний өдрийн "Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн сургалтад дэмжлэг үзүүлэх тухай" А/271 дүгээр тушаал, Батлан хамгаалахын сайдын 2026 оны А/50 дугаар тушаал, Засгийн газрын батлан хамгаалах зарим чиг үүргийг орон нутагт хэрэгжүүлэхээр Батлан хамгаалахын сайд, аймгийн Засаг даргатай 2026 онд хамтран ажиллахаар байгуулсан гэрээний 4.1 дэхь заалт, Цэргийн штабын 2026 оны сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн "Хээрийн дадлага" сургалтыг 2026 оны 06 дугаар сарын 18-22-ны өдрүүдэд Дэлгэр сумд зохион байгуулан явуулсугай.

2.Сургалтыг зохион байгуулах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

Аймгийн Засаг даргын 2026 оны
06 дугаар сарын 04-ны өдрийн 4 дүгээр
захирамжийн хавсралт 326

ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТЫН ХЭЭРИЙН ДАДЛАГА,
СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн дарга:
Орлогч даргаар

Аймгийн ЗДТГ-ын дарга М.Насанбат
Цэргийн штабын тоо бүртгэлийн ахлах
офицер дэд хурандаа Г.Баасанцог

Гишүүдэд:

Зэвсэгт хүчний 341 дүгээр ангийн захирагч
хурандаа Л.Жамбалсүрэн
Аймгийн Цагдаагийн газрын дарга,
цагдаагийн хурандаа Д.Бүрэнбаатар

Орон нутгийн бэлтгэл, хамгаалалтын
сургалтын офицер дэд хурандаа Г.Цэдэв

Дайчилгааны офицер хошууч Г.Мөнхбаяр

Дэлгэр сумын Засаг дарга Ж.Дорждэрэм
Дэлгэр сумын Засаг даргын Тамгын
газрын дарга Т.Сүхбаатар

_ оОо _